

**ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ  
ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

**Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах тухай хууль**  
*/шинэчилсэн найруулга/*

**УЛААНБААТАР ХОТ  
2019 ОН**

## **АГУУЛГА**

### **Нэг.Ерөнхий үндэслэл**

**Хоёр. Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах тухай хуулийн төсөл батлагдан гарснаар иргэнд үүсэх зардлын тооцоо:**

- 2.1.иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 2.2.цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох;
- 2.3.тоон үзүүлэлтийг тооцох;
- 2.4.нийт дүнг тооцож гаргах;
- 2.5.хялбарчлах боломжийг шалгах.

**Гурав. Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах тухай хуулийн төсөл батлагдан гарснаар хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцоо:**

- 3.1.хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 3.2.нэг бүрийн зардлыг тооцох;
- 3.3.тоон үзүүлэлтийг тооцох;
- 3.4.нийт зардлын дүнг тооцож гаргах;
- 3.5.хялбарчлах боломжийг шалгах;
- 3.6.нэмэлт зардлыг тооцох.

**Дөрөв.Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах тухай хуулийн төсөл батлагдан гарснаар төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоо:**

- 4.1.төрийн байгууллагад шинээр нэмэгдэж байгаа болон өргөжиж байгаа чиг үүргийг тогтоох;
- 4.2.уг чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг тодорхойлох;
- 4.3.гарах зардлыг тооцох;
- 4.4.зардлыг нэгтгэн тооцох;
- 4.5.хувилбарыг нягталж зардлыг бууруулах боломжийг эрэлхийлэх.

**МОНГОЛ УЛСЫН ИРГЭН ГАДААДАД ЗОРЧИХ, ЦАГААЧЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ  
ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

**НЭГ.ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ**

Хууль тогтоомжийн тухай хуулийн<sup>1</sup> 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан зардлын тооцоог гаргав.

Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах, бууруулах талаар санал боловсруулахад энэхүү тайлан чиглэгдэх болно.

Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах тухай хуулийн төсөл зохицуулалтаар буюу хуулийн төсөл батлагдсанаар зардал үүсгэгч этгээдэд тодорхой үүрэг бий болгосон, түүнийг хэрэгжүүлэхэд мөнгөн зардал бий болохоор тусгагдсан байна.

Хуулийн төсөлд тусгагдсан иргэн, хуулийн этгээдийн хүлээж буй үүрэг, төрийн байгууллагын чиг үүрэгтэй холбоотой зардлыг тооцохыг өмнө Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн төсөл тухай хууль үйлчилж байгааг энд дурдах нь зүйтэй.

Хуулийн төслийн зардлыг тооцохдоо бодит статистик болон хугацааг шууд ашиглах боломжгүй тохиолдолд аргачлалын 2.5.2, 4.4.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн адил төстэй ажил, үйлчилгээ байгаа эсэхийг судалж, баримжаалах авах зэргээр хугацаа, тохиолдлын тоо зэргийг тогтоосон болно.

---

<sup>1</sup> “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн

## **ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ИРГЭН ГАДААДАД ЗОРЧИХ, ЦАГААЧЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДАЛ**

Хуулийн төсөл батлагдсанаар иргэнд үүсэх зардлыг тооцоолохдоо дараахь дарааллыг баримтална. Үүнд:

- иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох
- цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох
- тоон үзүүлэлтийг тооцох
- нийт дүнг тооцож гаргах
- хялбарчлах боломжийг шалгах

### **2.1.Иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох:**

Энэ үе шатанд Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах тухай хуулийн төсөлд тусгагдсан иргэний гүйцэтгэх үүргийг болон түүний мэдээллийн агуулгыг нэг бүрчлэн тодорхойлов.

Иргэний гүйцэтгэх үүрэг, түүний агуулгыг гаргасан байдал:

4.2.2.Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасны дагуу гадаад улсад байнга оршин суугаа иргэн нь иргэний цахим бүртгэлд заавал бүртгүүлэх, хаягийн өөрчлөлтийг хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газарт тухай бүрт мэдээлэх;

5.3.Гадаадад цагаачлах иргэн харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад дараахь баримт бичиг гаргаж өгнө:

5.3.1.цагаачлах хүсэлт;

5.3.2.оршин суугаа нутгийн захиргааны байгууллагын тодорхойлолт;

5.3.3.тухайн орны цагаачлалын асуудал эрхэлсэн байгууллагын зөвшөөрөл.

6.3.Энэ хуулийн 6.1-д заасан этгээд улсын хилээр хамт нэвтэрсэн хүүхдийг хилийн гадна үлдээсэн тохиолдолд түүнийг асран хамгаалалтад авч үлдсэн хүний талаархи мэдээлэл, тайлбар, нотлох баримтыг Монгол Улсын хил хамгаалах байгууллагад гаргаж өгнө.

### **2.2.Цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох**

Энэ үе шатанд дараахь үйл ажиллагаад хийгдэнэ.

- үүргийг гүйцэтгэхэд буюу үүргийн агуулга бүрийг бүрдүүлэхэд иргэний зүгээс хийгдэх стандарт ажиллагааг тогтоох
- уг стандарт ажиллагаанд зарцуулах хугацааг тодорхойлох
- иргэнээс шууд гарах зардлыг мөнгөн дүнгээр тооцоолох

Өмнөх шатанд тодорхойлсон үүрэг, түүний агуулгыг бүрдүүлэхэд иргэнээс зарцуулах хугацааг бодит нөхцөл байдалд тулгуурлан ердийн дундаж хугацаагаар баримжаалан гаргасан болно.

Хуулийн төслөөр иргэнд шинээр бий болгож байгаа үүргийг авч үзэх нь зүйтэй гэж үзсэн болно.

| д/д | Гүйцэтгэх үүрэг                                                                                                                                                                                                                                                                     | Мэдээллийн агуулга                                                                                 | Стандарт үйл ажиллагаа                       | Хугацаа |
|-----|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------|---------|
|     | 4.2.2.Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасны дагуу гадаад улсад байнга оршин суугаа иргэн нь иргэний цахим бүртгэлд заавал бүртгүүлэх, хаягийн өөрчлөлтийг хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газарт тухай бүрт мэдээлэх; | иргэний цахим бүртгэлд заавал бүртгүүлэх                                                           | Цахим хуудаст нэвтрэх, танилцах              | 10      |
|     |                                                                                                                                                                                                                                                                                     |                                                                                                    | Холбогдох бүртгэл бүртгүүлэх                 | 10      |
|     |                                                                                                                                                                                                                                                                                     |                                                                                                    | Нягтлах, баталгаажуулах                      | 5       |
|     |                                                                                                                                                                                                                                                                                     | хаягийн өөрчлөлтийг хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газарт тухай бүрт мэдээлэх | Дипломат төлөөлөгчийн газар хандах           | 10      |
|     |                                                                                                                                                                                                                                                                                     |                                                                                                    | Хаягийн өөрчлөлтийг мэдээлэх, баталгаажуулах | 10      |
|     |                                                                                                                                                                                                                                                                                     | НИЙТ ЗАРЦУУЛАХ ХУГАЦАА /дээрх үүргийг нэг удаа хэрэгжүүлэхэд иргэний зарцуулах хугацаа/            |                                              |         |

### 2.3.Тоон үзүүлэлтийг тооцож гаргах:

Өмнөх хэсэгт дурдагдсан хуулийн төслөөр иргэн гүйцэтгэхээр болж байгаа үүргийг хэдэн иргэн, жилд хэдэн удаа хэрэгжүүлэхийг энэ үе шатанд тооцоолон гаргана.

Энэ тохиолдолд байнга оршин суудаг хэдэн иргэн нэг жилд бүртгэл хийлгэх вэ тооцоолол гаргах шаардлагатай болно.

Тоон үзүүлэлтийг тохиолдлын тоо буюу уг үүргийг хэдэн иргэн гүйцэтгэх ёстойг, давтамжийн тоо буюу дээрх иргэдэд уг үүргийг жилд хэдэн удаа давтан гүйцэтгэхээр тусгасныг үзүүлэлтээр тооцно. Үүнийг аргачлалын дагуу дараахь томъёогоор тооцно.

#### ТООН ҮЗҮҮЛЭЛТ = ТОХИОЛДЛЫН ТОО x ДАВТАМЖИЙН ТОО

Тохиолдлын тоог гаргах асуудал нь манай тохиолдлын хувьд бага зэрэг хүндрэлтэй байсан болно.

Байнга оршин суугаа иргэдийн тоо /Үндэсний статистикийн хороо 2019/<sup>2</sup>

|                   | 2008  | 2009  | 2010  | 2011  | 2012  | 2013   | 2014   | 2015  | 2016   | 2017   | 2018   |
|-------------------|-------|-------|-------|-------|-------|--------|--------|-------|--------|--------|--------|
| Байнга оршин суух | 4,724 | 5,940 | 9,377 | 7,737 | 9,125 | 11,121 | 12,419 | 6,768 | 11,959 | 13,758 | 16,307 |

<sup>2</sup> Nso.mn

Иймд тохиолдлын тоо буюу нэг жилд бүртгүүлэх гадаадад байнга оршин суугаар иргэний тоог гаргахдаа аргачлалын дагуу баримжаалж гаргах шаардлагатай болно.

Иймд дээрх мэдээллийг үндэслэн 2008-2018 онд гадаадад байнга оршин суугаа иргэдийн 10 жилийн дундажаар баримжаалахад нэг жилд дундажаар 10923 иргэн байна. Харин тооцооллыг илүү бодитой гаргахын тул энэүүл сүүлийн 10 жилийн хугацаанд байнга оршин суух иргэн нь жилд дунджаар 1154 иргэнээр нэмэгдэж байсан байна. Иймд тохиолдлын тоо 1154 болно.

Давтамжийг хуулийн төсөлд ямар хугацаанд хэдэн удаа бүртгүүлэхийг тодорхой тусгаагүй тул Жилд 1 удаа гэж тооцон 1 гэж үзнэ. Иймд тоон үзүүлэлт дараахь байдлаар гарна.

| Хүснэгт 4 |                                                                                                                                                                                                                                                                                    |                |   |                |   |               |
|-----------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------|---|----------------|---|---------------|
| д/д       | Гүйцэтгэх үүрэг                                                                                                                                                                                                                                                                    | Тохиолдлын тоо | х | Давтамжийн тоо | = | Тоон үзүүлэлт |
| 1         | .2.2.Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасны дагуу гадаад улсад байнга оршин суугаа иргэн нь иргэний цахим бүртгэлд заавал бүртгүүлэх, хаягийн өөрчлөлтийг хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газарт тухай бүрт мэдээлэх; | 1154           | х | 1              | = | 1154          |

#### 2.4.Нийт дүнг тооцоолж гаргах:

Энэ шатанд хуулийн төслийн хүрээнд иргэнд шинээр бий болсон үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тэдэнд үүсэх ачааллыг цаг хугацаагаар тооцоолон гаргана. Иргэнд үүсэх ачаалал нь өмнөх үе шатуудад тооцоолон гаргасан цаг хугацааны зарцуулалтыг тоон үзүүлэлтээр үржүүлснээр тодорхойлогдоно.

**АЧААЛАЛ = ЦАГ ХУГАЦААНЫ ЗАРЦУУЛАЛТ Х ТООН ҮЗҮҮЛЭЛТ**

Хуулийн төсөлд тусгасан дээрх үүргийг хэрэгжүүлэхэд дараахь мөнгөн зардал гарахаар тооцооллоо.

| Хүснэгт 5                                                           |                                                                                                                                                                                                                                                                                    |                   |                                   |                                         |
|---------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------|-----------------------------------|-----------------------------------------|
| ИРГЭН ХУУЛЬД ЗААСАН ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭХЭД ҮҮСЭХ ЦАГ ХУГАЦААНЫ АЧААЛАЛ |                                                                                                                                                                                                                                                                                    |                   |                                   |                                         |
| д/д                                                                 | Гүйцэтгэх үүрэг                                                                                                                                                                                                                                                                    | Зарцуулах хугацаа | Тоон үзүүлэлт /хамрагдагсдын тоо/ | Нийт иргэнд үүсэх цаг хугацааны ачаалал |
| 1                                                                   | .2.2.Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасны дагуу гадаад улсад байнга оршин суугаа иргэн нь иргэний цахим бүртгэлд заавал бүртгүүлэх, хаягийн өөрчлөлтийг хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газарт тухай бүрт мэдээлэх; | 45                | 1154                              | 51930                                   |
|                                                                     | <b>Иргэнд үүсэх нийт ачаалал</b>                                                                                                                                                                                                                                                   |                   |                                   | <b>51.930 мин</b>                       |

Иргэнд үүсгэж байгаа нийт мөнгөн зардлыг тооцоолохдоо нэрлэгдсэн тухайн үүргийг гүйцэтгэхэд хууль, тогтоомжид заасан мөнгөн дүн бүхий зардлыг тоон үзүүлэлтээр үржүүлэх замаар тооцоолон гаргана.

Хүснэгт 6

| <b>ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР ИРГЭН ХУУЛЬД ЗААСАН ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭХЭД ҮҮСЭХ МӨНГӨН ЗАРДАЛ</b> |                                 |               |   |               |   |                    |
|------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------|---------------|---|---------------|---|--------------------|
| д/д                                                                                            | Гүйцэтгэх үүрэг                 | Тоон үзүүлэлт | х | Мөнгөн зардал | = | Нийт мөнгөн зардал |
| 1                                                                                              | Баримт бичиг хуулбарлан хувилах | 248100        | Х | 200           | = | 49.620,000         |
| 2                                                                                              | Шуудангийн зардал               | 248100        |   | 500           |   | 124.050,000        |
|                                                                                                | <b>НИЙТ МӨНГӨН ЗАРДАЛ</b>       |               |   |               |   | <b>129.010.000</b> |

6.3.Энэ хуулийн 6.1-д заасан этгээд улсын хилээр хамт нэвтэрсэн хүүхдийг хилийн гадна үлдээсэн тохиолдолд түүнийг асран хамгаалалтад авч үлдсэн хүний талаархи мэдээлэл, тайлбар, нотлох баримтыг Монгол Улсын хил хамгаалах байгууллагад гаргаж өгнө.

| д/д | Гүйцэтгэх үүрэг                                                                                                                                                                                                                                        | Мэдээллийн агуулга                      | Стандарт үйл ажиллагаа          | Хугацаа |
|-----|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------|---------------------------------|---------|
|     | 6.3.Энэ хуулийн 6.1-д заасан этгээд улсын хилээр хамт нэвтэрсэн хүүхдийг хилийн гадна үлдээсэн тохиолдолд түүнийг асран хамгаалалтад авч үлдсэн хүний талаархи мэдээлэл, тайлбар, нотлох баримтыг Монгол Улсын хил хамгаалах байгууллагад гаргаж өгнө. | Мэдээлэл, тайлбар, нотлох баримт гаргах | Нотлох баримтыг бүрдүүлэх       | 480     |
|     |                                                                                                                                                                                                                                                        |                                         | Хил хамгаалах байгууллагад өгөх | 30      |
|     | НИЙТ ЗАРЦУУЛАХ ХУГАЦАА /дээрх үүргийг нэг удаа хэрэгжүүлэхэд иргэний зарцуулах хугацаа/                                                                                                                                                                |                                         |                                 |         |

#### Тоон үзүүлэлт

| Итгэмжлэлтэй нэвтэрсэн хүүхэд 02.01-12.13. | Хилийн чанадад үлдсэн хүүхэд | Хүүхэдгүй буцаж ирсэн хүний тоо                |                        |
|--------------------------------------------|------------------------------|------------------------------------------------|------------------------|
|                                            |                              | Хүүхдийг үлдээсэн тухай нотлох баримт бичигтэй | Нотлох баримт бичиггүй |
| 20833                                      | 963                          | 63                                             | 900                    |

Иймд тохиолдлын тоог 963 гэж тооцов.

| <b>ИРГЭН ХУУЛЬД ЗААСАН ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭХЭД ҮҮСЭХ ЦАГ ХУГАЦААНЫ АЧААЛАЛ</b>                                                                                                                                                                             |                   |                                   |                                         |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------|-----------------------------------|-----------------------------------------|
| Гүйцэтгэх үүрэг                                                                                                                                                                                                                                        | Зарцуулах хугацаа | Тоон үзүүлэлт /хамрагдагсдын тоо/ | Нийт иргэнд үүсэх цаг хугацааны ачаалал |
| 6.3.Энэ хуулийн 6.1-д заасан этгээд улсын хилээр хамт нэвтэрсэн хүүхдийг хилийн гадна үлдээсэн тохиолдолд түүнийг асран хамгаалалтад авч үлдсэн хүний талаархи мэдээлэл, тайлбар, нотлох баримтыг Монгол Улсын хил хамгаалах байгууллагад гаргаж өгнө. | 510               | 963                               | 491130                                  |
| <b>Иргэнд үүсэх нийт ачаалал</b>                                                                                                                                                                                                                       |                   |                                   | <b>491.130 мин</b>                      |

## **2.5.Хувилбарыг нягталж, хялбарчлах боломжийг шалгах:**

Хуулийн төслөөр иргэнд үүсэх зардлыг тооцооны судалгаагаар Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтад заасны дагуу иргэдэд үүсч байгаа үүргийг хэрэгжүүлэхэд иргэнээс шаардагдах мөнгөн болон цаг хугацааны ачааллыг тооцоолов. Тооцооллыг гаргахдаа хуулийн төслөөр иргэнд шинээр бий болгосон үүргийг хэрэгжүүлэхийн тулд иргэнээс шаардсан баримт бичиг, түүнийг хэрэгжүүлэхийн тулд иргэний гүйцэтгэх үйл ажиллагааг гаргах замаар цаг хугацааг тогтоолоо. Мөнгөн зардлыг хууль тогтоомжоор бий болгосон албан ёсны эх сурвалжийг ашиглан баримжаалах замаар тогтоов.

Хуулийн төслийн 2.2.Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасны дагуу гадаад улсад байнга оршин суугаа иргэн нь иргэний цахим бүртгэлд заавал бүртгүүлэх, хаягийн өөрчлөлтийг хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газарт тухай бүрт мэдээлэх, 6.3.Энэ хуулийн 6.1-д заасан этгээд улсын хилээр хамт нэвтэрсэн хүүхдийг хилийн гадна үлдээсэн тохиолдолд түүнийг асран хамгаалалтад авч үлдсэн хүний талаархи мэдээлэл, тайлбар, нотлох баримтыг Монгол Улсын хил хамгаалах байгууллагад гаргаж өгнө. Зэрэг заалтуудаар иргэнд үүрэг хүлээлгэсэн байна.

Эдгээр зохицуулалтуудад иргэнд үүсэх зардлыг аргачлалын дагуу цаг хугацааны ачааллаар тооцвол гадаад улсад байнга оршин суугаа иргэн нь иргэний цахим бүртгэлд заавал бүртгүүлэх, хаягийн өөрчлөлтийг хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газарт тухай бүрт мэдээлэх үүргийг хэрэгжүүлэхэд нэг жилд дунджаар 1154 иргэн нь 51930 минут, хүүхдийг хилээр авч гарсан этгээд улсын хилээр хамт нэвтэрсэн хүүхдийг хилийн гадна үлдээсэн тохиолдолд түүнийг асран хамгаалалтад авч үлдсэн хүний талаархи мэдээлэл, тайлбар, нотлох баримтыг Монгол Улсын хил хамгаалах байгууллагад гаргаж өгөхөд 963 иргэн 491.130 минут тус тус зарцуулахаар байна.

Иймд хуулийн төслийн зохицуулалад хамаарах иргэнд нийт 543062 минут буюу **9051** цаг зарцуулахаар тооцоолол гарлаа.

## **ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ИРГЭН ГАДААДАД ЗОРЧИХ, ЦАГААЧЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО**

Энэ хэсэгт Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах тухай хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдийн эрхлэх үйл ажиллагаатай холбоотой гүйцэтгэх үүргийн улмаас үүсэх зардлыг мөнгөн дүнгээр тооцоолон гаргана. Ийнхүү үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу дараахь үе шаттайгаар тооцоолно.

Үүнд:

- хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох
- нэг бүрийн зардлыг тооцох
- тоон үзүүлэлтийг тооцох
- нийт зардлын дүнг тооцож гаргах
- хялбарчлах боломжийг шалгах
- нэмэлт зардлыг тооцох

### **3.1.Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох:**

Хуулийн төслийн хүрээнд хуулийн этгээдэд ямар үүргийг шинээр бий болгож байгааг тодорхойлж уг үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай баримт бичгийн агуулгыг тодорхойлсны үндсэн дээр зардлын тооцоог хийх болно.

Засгийн газрын 2019 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 2.2-т “Хуулийн этгээдийн хувьд хууль тогтоомжид заасан үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан гарах **мөнгөн зардлыг** тооцно.” гэж заасан.

Хуулийн төсөлд хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн, тодорхой мөнгөн зардал бий болгохоор тусгасан зохицуулалт тусгагдаагүй байх тул энэ хэсгийг тусгайлан тооцоолол гаргах шаардлагагүй болно.

## **ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН ИРГЭН ГАДААД ЗОРЧИХ, ЦАГААЧЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДАГУУ УЛСЫН ТӨСӨВТ ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО**

### **3.2.Хүний нөөцийн хэрэгцээг тооцох**

Хуулийн төсөлд төрийн байгууллагад шинэ чиг үүрэг нэмэгдүүлсэн, үүнтэй холбогдуулан тодорхой мөнгөн зардал бий болохоор тусгагдсан байх тул төрд үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолно. Үүнд:

- 4.1.төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээг тодорхойлох;
- 4.2. уг чиг үүргийг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;
- 4.3. гарах зардлыг тооцох;
- 4.4. зардлыг нэгтгэн тооцох;
- 4.5. хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.

Энэ шатанд төрийн байгууллагын ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд зарцуулах хугацаа болон жилд гүйцэтгэх тоо буюу тохиолдлын тоо, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт ажлын цаг гэсэн 3 үзүүлэлтийг гаргана.

Стандарт үйл ажиллагаа болон зарцуулах хугацааг тодорхойлохдоо Засгийн газрын 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтад заасан хугацааг харгалзан үзэхийн хамт бусад ижил төстэй ажил үйлчилгээг ердийн дундаж албан хаагч гүйцэтгэх хугацааг мөн үндэслэсэн болно.

Тохиолдын тоог гаргахын тулд дараахь мэдээллийг ашиглая. Хуулийн төсөл батлагдан гарснаар шинээр бий болсон дээрх үүргийг жилд хэдэн удаа гүйцэтгэх вэ гэдгийг хуанлийн нэг жилээр тооцоолон гаргах

**Хуулийн төсөл дэх төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг /ажил үйлчилгээ/, түүний агуулгыг тодорхойлбол:**

6.4.Энэ хуулийн 6.3-т заасан байгууллага нь насанд хүрээгүй хүнийг үлдээсэн шалтгааныг нь тодруулж, шаардлагатай гэж үзвэл тухайн асуудлыг цагдаагийн байгууллагад шалгуулахаар шилжүүлнэ.

8.1.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт заасан сангийн үйл ажиллагааг зохицуулах үүрэг бүхий зөвлөл /цаашид зөвлөл гэнэ/ ажиллана.

9.4.Хилийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлсэн Монгол Улсын иргэдийн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтөлнө.

9.5.Монгол Улсын иргэний гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх эрх бүхий байгууллагууд нь тухайн иргэний гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлсэн, сунгасан,

түдгэлзүүлсэн шийдвэрийг хүчингүй болгосон талаархи мэдээллийг хил хамгаалах байгууллагад нэн даруй мэдээлнэ.

10.1.1.гадаадад зорчсон, түр болон байнга оршин суугаа иргэдийн зорилгыг үндэслэн төрөлжсөн мэдээллийн сан бүрдүүлж, хөтлөх;

10.1.2.гадаадад нарийн мэргэжил эзэмшсэн иргэдийн мэдлэг, боловсролыг ашиглах, Монгол Улсад нутагших нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор энэ хуулийн 10.1.1-д заасан санд бүртгэлтэй их, дээд сургууль болон тодорхой хугацааны сургалтад хамрагдаж байгаа иргэдийн мэдээллийг тэдгээрийн зөвшөөрөлтэйгөөр Монгол Улсын төрийн байгууллага, ажил олгогч хуулийн этгээдэд нээлттэй ашиглах боломжийг бүрдүүлж ажиллах.

11.3.Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь гадаад улсын ажиллах хүчний талаар баримталж байгаа бодлого, шийдвэрийн Монгол Улсын ажиллах хүчний шилжилт, хөдөлгөөнд нөлөөлөх нөлөөллийн талаар судалгаа, дүн шинжилгээ хийж Засгийн газарт тухай бүр танилцуулна.

Тохиолдын тоог: Хил хамгаалах ерөнхий газраас ирүүлсэн 2017 онд цагдаагийн байгууллагад шилжүүлсэн тоо<sup>3</sup>

| Итгэмжлэлтэй нэвтэрсэн хүүхэд 02.01-12.13. | Буцаагдсан хүүхэд 02.01-12.13. | Хилийн чанадад үлдсэн хүүхэд | Хүүхэдгүй буцаж ирсэн хүний тоо                       |                              | Цагдаагийн байгууллагад шилжүүлэн шалгуулсан хүний тоо |
|--------------------------------------------|--------------------------------|------------------------------|-------------------------------------------------------|------------------------------|--------------------------------------------------------|
|                                            |                                |                              | Хүүдийнээ үлдээсэн тухай нотлох баримт бичигтэй ирсэн | Нотлох баримт бичиггүй ирсэн |                                                        |
| 20833                                      | 176                            | <b>963</b>                   | 63                                                    | 900                          | 10                                                     |

Дээрх хүснэгтийг үндэслэн хилийн чанадад үлдээсэн хүүхэдтэй холбоотой зохицуулалтын тухайд тохиолдлын тоог 963 гэж тооцов.

Мөн “Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан” нь 2009-2017 онд өргөдөл гаргасан иргэдэд Дипломат төлөөлөгчийн газруудаар дамжуулан 1.3 тэрбум гаруй төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлжээ. Сангийн хөрөнгийн 40-50 хувийг нас барсан иргэний шарилыг эх оронд нь авчрахад зарцуулдаг байна. Үлдэх хувийг гадаадад ял эдэлж байгаа иргэдээ эргэх, гэмт хэргийн улмаас хохирсон, эд хөрөнгөө гэж төлбөрийн чадваргүй болсон иргэдийг эх оронд нь буцаах зэрэгт олгодог судалгаа гарчээ. Хамгийн сүүлийн мэдээгээр тус сангаас зөвхөн энэ онд л 182,715,550 төгрөгийг зарцуулаад байгаа аж.

Жилд дундажаар 5 иргэнд тус сангаас журамд заасан шаардлагын дагуу тусламж үзүүлсэн байдаг. Иймд тохиолдлын тоог 5 гэж авав.

Түүнчлэн байнга оршин суугаа иргэдийн тоо /Үндэсний статистикийн хороо 2019/<sup>4</sup>

|  | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 |
|--|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|
|--|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|

<sup>3</sup> Хил хамгаалах ерөнхий газар

<sup>4</sup> Nso.mn

|                         |       |       |       |       |       |        |        |       |        |        |        |
|-------------------------|-------|-------|-------|-------|-------|--------|--------|-------|--------|--------|--------|
| Байнга<br>оршин<br>суух | 4,724 | 5,940 | 9,377 | 7,737 | 9,125 | 11,121 | 12,419 | 6,768 | 11,959 | 13,758 | 16,307 |
|-------------------------|-------|-------|-------|-------|-------|--------|--------|-------|--------|--------|--------|

Иймд тохиолдлын тоо буюу нэг жилд бүртгүүлэх гадаадад байнга оршин суугаар иргэний тоог гаргахдаа аргачлалын дагуу баримжаалж гаргах шаардлагатай болно.

Иймд дээрх мэдээллийг үндэслэн 2008-2018 онд гадаадад байнга оршин суугаа иргэдийн 10 жилийн дундажаар баримжаалахад нэг жилд дундажаар 10923 иргэн байна. Харин тооцооллыг илүү бодитой гаргахын тул сүүлийн 10 жилийн хугацаанд байнга оршин суух иргэн нь жилд дунджаар 1154 иргэнээр нэмэгдэж байсан байна. Иймд тохиолдлын тоо 1154 болно.

| Гүйцэтгэх үүрэг                                                                                                                                                                            | Үүргийн мэдээллийн агуулга        | Стандарт үйл ажиллагаа                     | Хугацаа минут | Тохиолдлын | Хүний нөөцийн хэрэгцээ |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------|--------------------------------------------|---------------|------------|------------------------|
| 6.4.Энэ хуулийн 6.3-т заасан байгууллага нь насанд хүрээгүй хүнийг үлдээсэн шалтгааныг нь тодруулж, шаардлагатай гэж үзвэл тухайн асуудлыг цагдаагийн байгууллагад шалгуулахаар шилжүүлнэ. | шалтгааныг нь тодруулж            | баримт бичиг шалгах                        | 10            | 963        | 9630                   |
|                                                                                                                                                                                            |                                   | нэмэлт тодруулага авах                     | 10            | 963        | 9630                   |
|                                                                                                                                                                                            | цагдаагийн байгууллагад шилжүүлэх | мэдээллийг нягтлах                         | 20            | 963        | 19260                  |
|                                                                                                                                                                                            |                                   | эрх бүхий этгээдэд танилцуулах             | 20            | 10         | 200                    |
|                                                                                                                                                                                            |                                   | цагдаагийн байгууллагад мэдээлэл шилжүүлэх | 30            | 10         | 300                    |
|                                                                                                                                                                                            |                                   | <b>нийт дүн</b>                            |               |            | <b>39020</b>           |
| 8.1.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт заасан сангийн үйл ажиллагааг зохицуулах үүрэг бүхий зөвлөл /цаашид зөвлөл гэнэ/ ажиллана.              | хөрөнгийг зарцуулах,              | өргөдөл хүлээн авах                        | 480           | 5          | 2400                   |
|                                                                                                                                                                                            |                                   | өргөдлийн агуулгыг нягтлах                 | 480           | 5          | 2400                   |
|                                                                                                                                                                                            |                                   | хуралдаан зохион байгуулах                 | 480           | 5          | 2400                   |
|                                                                                                                                                                                            | гүйцэтгэлийг тайлагнах            | хуралдаанаар хэлэлцэж, шийдвэр гаргах      | 1440          | 5          | 7200                   |
|                                                                                                                                                                                            | хянахтай                          | хөрөнгийг олгох                            | 1440          | 5          | 7200                   |
|                                                                                                                                                                                            |                                   | <b>нийт дүн</b>                            |               |            | <b>216000</b>          |
| 9.4.Хилийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлсэн Монгол Улсын иргэдийн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтөлнө.                    | Сан бүрдүүлэх                     | мэдээлэл хүлээн авч                        | 5             | 810        | 405                    |
|                                                                                                                                                                                            | Эрхлэн хөтлөх                     | санд бүртгэх                               | 5             | 810        | 405                    |
|                                                                                                                                                                                            |                                   | нягтлах                                    | 5             | 810        | 405                    |
|                                                                                                                                                                                            |                                   | баталгаажуулах                             | 10            | 810        | 810                    |
|                                                                                                                                                                                            |                                   | эрх бүхий байгууллагад мэдээлэл өгөх       | 30            | 810        | 24300                  |
|                                                                                                                                                                                            |                                   | <b>нийт дүн</b>                            |               |            | <b>26325</b>           |

|                                                                                                                                                                                                                                                                                                                                      |                                        |                                        |     |      |               |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------|----------------------------------------|-----|------|---------------|
| 9.5.Монгол Улсын иргэний гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх эрх бүхий байгууллагууд нь тухайн иргэний гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлсэн, сунгасан, түдгэлзүүлсэн шийдвэрийг хүчингүй болгосон талаархи мэдээллийг хил хамгаалах байгууллагад нэн даруй мэдээлнэ.                                           | Түдгэлзүүлсэн мэдээллийг хүргүүлэх     | түдгэлзүүлсэн мэдээллийг хүргүүлэх     | 110 | 810  | 93150         |
|                                                                                                                                                                                                                                                                                                                                      | Сунгасан мэдээллийг хүргүүлэх          | сунгасан мэдээллийг хүргүүлэх          |     |      |               |
|                                                                                                                                                                                                                                                                                                                                      | Хүчингүй болгосон мэдээллийг хүргүүлэх | хүчингүй болгосон мэдээллийг хүргүүлэх |     |      |               |
| 10.1.1.гадаадад зорчсон, түр болон байнга оршин суугаа иргэдийн зорилгыг үндэслэн төрөлжсөн мэдээллийн сан бүрдүүлж, хөтлөх;                                                                                                                                                                                                         | Сан бүрдүүлэх                          | бүртгэх                                | 10  | 1154 | 11540         |
|                                                                                                                                                                                                                                                                                                                                      |                                        | мэдээлэл оруулах                       | 10  | 1154 | 11540         |
|                                                                                                                                                                                                                                                                                                                                      | Хөтлөх                                 | тодруулах                              | 30  | 1154 | 34620         |
|                                                                                                                                                                                                                                                                                                                                      |                                        | баталгаажуулах                         | 10  | 1154 | 11540         |
|                                                                                                                                                                                                                                                                                                                                      |                                        | эрх бүхий этгээдэд шилжүүлэх           | 30  | 1154 | 34620         |
|                                                                                                                                                                                                                                                                                                                                      |                                        | <b>нийт дүн</b>                        |     |      | <b>103860</b> |
|                                                                                                                                                                                                                                                                                                                                      |                                        |                                        |     |      |               |
| 11.3.Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь гадаад улсын ажиллах хүчний талаар баримталж байгаа бодлого, шийдвэрийн Монгол Улсын ажиллах хүчний шилжилт, хөдөлгөөнд нөлөөлөх нөлөөллийн талаар судалгаа, дүн шинжилгээ хийж Засгийн газарт тухай бүр танилцуулна | Судлах                                 | судлах                                 | 240 | 4    | 960           |
|                                                                                                                                                                                                                                                                                                                                      |                                        | орчуулах                               | 240 | 4    | 960           |
|                                                                                                                                                                                                                                                                                                                                      |                                        | нягтлах                                | 60  | 4    | 240           |
|                                                                                                                                                                                                                                                                                                                                      | Дүн шинжилгээ хийх                     | хэлэлцэх , дүгнэлт гаргах              | 60  | 4    | 960           |
|                                                                                                                                                                                                                                                                                                                                      |                                        | танилцуулгын төсөл боловсруулах        | 120 | 4    | 480           |
|                                                                                                                                                                                                                                                                                                                                      |                                        | төслийн хүргүүлэх                      | 30  | 4    | 120           |
|                                                                                                                                                                                                                                                                                                                                      |                                        | Засгийн газар танилцуулах              | 120 | 4    | 480           |
|                                                                                                                                                                                                                                                                                                                                      | Засгийн газарт танилцуулах             | <b>нийт дүн</b>                        |     |      | <b>3240</b>   |

**Төрийн байгууллагад үүсэх хүний нөөцийн хэрэгцээг дээрх мэдээллүүдийг ашиглан дараахь байдлаар гаргана.**

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдсан ажиллах цагийн горимтой харьцуулах авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200<sup>5</sup> өдөр

1 өдөр = ажлын 8 цаг /Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу/

1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу /200 x 8/ 1600 ажлын цаг буюу /1,600 x 60/ 96000 минут ажиллана гэсэн үг.

Нийт зарцуулах хугацаагаар хүний нөөцийн хэрэгцээ тодорхойлогдох ба тэрхүү хугацааг нэг жилд ажиллах ажлын минутад хувааснаар шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээ буюу ажлын байрны тоо гарна. Үүнийг дараахь байдлаар гаргана.

Хүснэгт 5

| Нэгж                                                                  | Хэрэгжүүлэх чиг үүрэг                                                                                                                                               | Хүний нөөцийн хэрэгцээ/мин | Жилд шаардагдах ажлын цаг/мин | Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/ |
|-----------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------|-------------------------------|---------------------------------|
| Хил хамгаалах байгууллага                                             | насанд хүрээгүй хүнийг үлдээсэн шалтгааныг нь тодруулж, шаардлагатай гэж үзвэл тухайн асуудлыг цагдаагийн байгууллагад шалгуулахаар шилжүүлэх                       | 39020                      | 96000                         | 0.4                             |
| Гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага | Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт заасан сангийн үйл ажиллагааг зохицуулах үүрэг бүхий зөвлөл                          | 21600                      | 96000                         | 0.2                             |
| Хил хамгаалах байгууллага                                             | Хилийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлсэн Монгол Улсын иргэдийн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтөлнө. | 26315                      | 96000                         | 0.3                             |
| Шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага                 | Монгол Улсын иргэний гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх эрх бүхий байгууллагууд нь тухайн иргэний гадаадад зорчих, цагаачлах эрхийг                     | 93150                      | 96000                         | 0.9                             |

<sup>5</sup> Хуанлийн 365 хоногоос хөдөлмөрийн хуулинд заасан нийтээр амрах байрын өдөр, ээлжийн амралт, хагас бүтэн сайн өдөр зэргийг хасаж бодитой ажиллах өдрийг тооцно.

|                                                                                                         |                                                                                                                                                                                                                         |        |       |     |
|---------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------|-------|-----|
|                                                                                                         | түдгэлзүүлсэн, сунгасан, түдгэлзүүлсэн шийдвэрийг хүчингүй болгосон талаархи мэдээллийг хил хамгаалах байгууллагад нэн даруй мэдээлнэ.                                                                                  |        |       |     |
| Дипломат төлөөлөгчийн газар                                                                             | 10.1.1.гадаадад зорчсон, түр болон байнга оршин суугаа иргэдийн зорилгыг үндэслэн төрөлжсөн мэдээллийн сан бүрдүүлж, хөтлөх;                                                                                            | 103860 | 96000 | 1   |
| Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага | нь гадаад улсын ажиллах хүчний талаар баримталж байгаа бодлого, шийдвэрийн Монгол Улсын ажиллах хүчний шилжилт, хөдөлгөөнд нөлөөлөх нөлөөллийн талаар судалгаа, дүн шинжилгээ хийж Засгийн газарт тухай бүр танилцуулна | 3240   | 96000 | 0.3 |

Хүснэгтээс харахад хуулийн төсөлд тусгагдсаны дагуу хил хамгаалах байгууллага нь насанд хүрээгүй хүнийг үлдээсэн шалтгааныг нь тодруулж, шаардлагатай гэж үзвэл тухайн асуудлыг цагдаагийн байгууллагад шалгуулахаар шилжүүлэх үүргийг хил хамгаалах байгууллага хэрэгжүүлэхэд жилд 0.4, гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлсэн Монгол Улсын иргэдийн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх чиг үүргийг хэрэгжүүлэхэд 0.3, Гадаад харилцааны яам нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт заасан сангийн үйл ажиллагааг зохицуулах үүрэг бүхий зөвлөлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд 0.2, эрх бүхий этгээд буюу шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь Монгол Улсын иргэний гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх эрх бүхий байгууллагууд нь тухайн иргэний гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлсэн, сунгасан, түдгэлзүүлсэн шийдвэрийг хүчингүй болгосон талаархи мэдээллийг хил хамгаалах байгууллагад нэн даруй мэдээлэх чиг үүргийг хэрэгжүүлэхэд 0.9, хилийн чанадад ажиллаж байгаа ДТГ нь гадаадад зорчсон, түр болон байнга оршин суугаа иргэдийн зорилгыг үндэслэн төрөлжсөн мэдээллийн сан бүрдүүлж, хөтлөх чиг үүргийг хэрэгжүүлэхэд Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гадаад улсын ажиллах хүчний талаар баримталж байгаа бодлого, шийдвэрийн Монгол Улсын ажиллах хүчний шилжилт, хөдөлгөөнд нөлөөлөх нөлөөллийн талаар судалгаа, дүн шинжилгээ хийж Засгийн газарт тухай бүр танилцуулах үүргийг хэрэгжүүлэхэд 0.3 орон тоо тус тус шаардлагатай гэсэн тооцоолол гарсан байна.

Өөрөөр хэлбэл дээрх төрийн байгууллагуудад шинээр хүний нөөцийн зардал гарахгүй бөгөөд одоо байгаа орон тоон дээр холбогдох албан хаагчдаар хавсруулан гүйцэтгэх боломжтой байна.

## ТАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн<sup>6</sup> 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан зардлын тооцоог гаргалаа.

Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах тухай хуулийн төсөл үйлчилж байгааг дурдах нь зүйтэй. Тухайлбал: гадаадад цагаачлах иргэд холбогдох байгууллагад хүсэлт гаргах, зөвшөөрөл олгох, гадаадад гамшиг осол тохиолдох үед сэрэмжлүүлэх, холбогдох арга хэмжээ авах зэрэг үүргүүд хэрэгжиж ирсэн.

Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах тухай хуулийн холбоотой холбогдох бусад хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа тул хуулийн төсөлд зөвхөн шинээр бий болж байгаа тодорхой үүрэгтэй холбогдуулан гарах зардлыг тооцсон болно.

Хуулийн төсөлд тусгагдсан зардлыг тооцохын тул бодит статистик болон хугацааг шууд ашиглах боломжгүй тохиолдолд аргачлалын 2.5.2, 4.4.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн адил төстэй ажил, үйлчилгээ байгаа эсэхийг судалж, баримжаалах авах зэргээр хугацаа, тохиолдлын тоо зэргийг тогтоосон бөгөөд тухай бүрт тайлбарыг оруулсан болно.

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” аргачлалын дагуу иргэнд үүсэх зардал нь цаг хугацаагаар, хуулийн этгээдэд үүсэх зардал нь мөнгөн дүнгээр, төрийн байгууллагад үүсэх зардал нь хүний нөөцийн хэрэгцээгээр тооцогдог. Эдгээр тооцож гаргасан зардлууд дээр “бусад зардал”, “нэмэлт зардал” буюу мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх зардлыг мөн тооцсон болно.

Хуулийн төслөөр иргэнд үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтад заасны дагуу иргэдэд үүсч байгаа үүргийг хэрэгжүүлэхэд иргэнээс шаардагдах мөнгөн болон цаг хугацааны ачааллыг тооцоолов. Тооцооллыг гаргахдаа хуулийн төслөөр иргэнд шинээр бий болгосон үүргийг хэрэгжүүлэхийн тулд иргэнээс шаардсан баримт бичиг, түүнийг хэрэгжүүлэхийн тулд иргэний гүйцэтгэх үйл ажиллагааг гаргах замаар цаг хугацааг тогтоолоо. Мөнгөн зардлыг хууль тогтоомжоор бий болгосон албан ёсны эх сурвалжийг ашиглан баримжаалах замаар тогтоов.

Хуулийн төслийн 2.2.Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасны дагуу гадаад улсад байнга оршин суугаа иргэн нь иргэний цахим бүртгэлд заавал бүртгүүлэх, хаягийн өөрчлөлтийг хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газарт тухай бүрт мэдээлэх, 5.3-т Гадаадад цагаачлах иргэн харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад дараахь баримт бичиг

---

<sup>6</sup> “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн

гаргаж өгнө, 6.3.Энэ хуулийн 6.1-д заасан этгээд улсын хилээр хамт нэвтэрсэн хүүхдийг хилийн гадна үлдээсэн тохиолдолд түүнийг асран хамгаалалтад авч үлдсэн хүний талаархи мэдээлэл, тайлбар, нотлох баримтыг Монгол Улсын хил хамгаалах байгууллагад гаргаж өгнө. Зэрэг заалтуудаар иргэнд үүрэг хүлээлгэсэн байна.

Эдгээр зохицуулалтуудад иргэнд үүсэх зардлыг аргачлалын дагуу цаг хугацааны ачааллаар тооцвол гадаад улсад байнга оршин суугаа иргэн нь иргэний цахим бүртгэлд заавал бүртгүүлэх, хаягийн өөрчлөлтийг хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газарт тухай бүрт мэдээлэх үүргийг хэрэгжүүлэхэд нэг жилд дунджаар 1154 иргэн нь 51930 минут, Гадаадад цагаачлах иргэн харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад цагаачлах хуульд заасан баримт бичгийг бүрдүүлэх хүсэлт гаргахад 0.4 иргэн 16 минут, хүүхдийг хилээр авч гарсан этгээд улсын хилээр хамт нэвтэрсэн хүүхдийг хилийн гадна үлдээсэн тохиолдолд түүнийг асран хамгаалалтад авч үлдсэн хүний талаархи мэдээлэл, тайлбар, нотлох баримтыг Монгол Улсын хил хамгаалах байгууллагад гаргаж өгөхөд 963 иргэн 491.130 минут тус тус зарцуулахаар байна.

Иймд хуулийн төслийн зохицуулалтад хамаарах иргэнд нийт 543076 минут буюу **9051** цаг зарцуулахаар тооцоолол гарлаа.

Засгийн газрын 2019 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 2.2-т “Хуулийн этгээдийн хувьд хууль тогтоомжид заасан үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан гарах **мөнгөн зардлыг** тооцно.” гэж заасан.

Хуулийн төсөлд хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн, тодорхой мөнгөн зардал бий болгохоор тусгасан зохицуулалт тусгагдаагүй байх тул энэ хэсгийг тусгайлан тооцоолол гаргах шаардлагагүй болно.

Хуулийн төсөлд тусгагдсаны дагуу хил хамгаалах байгууллага нь насанд хүрээгүй хүнийг үлдээсэн шалтгааныг нь тодруулж, шаардлагатай гэж үзвэл тухайн асуудлыг цагдаагийн байгууллагад шалгуулахаар шилжүүлэх үүргийг хил хамгаалах байгууллага хэрэгжүүлэхэд жилд 0.4, гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлсэн Монгол Улсын иргэдийн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх чиг үүргийг хэрэгжүүлэхэд 0.3, Гадаад харилцааны яам нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт заасан сангийн үйл ажиллагааг зохицуулах үүрэг бүхий зөвлөлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд 0.2, эрх бүхий этгээд буюу шүүх, прокурор, гүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь Монгол Улсын иргэний гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх эрх бүхий байгууллагууд нь тухайн иргэний гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлсэн, сунгасан, түдгэлзүүлсэн шийдвэрийг хүчингүй болгосон талаархи мэдээллийг хил хамгаалах байгууллагад нэн даруй мэдээлэх чиг үүргийг хэрэгжүүлэхэд 0.9, хилийн чанадад ажиллаж байгаа ДТГ нь гадаадад зорчсон, түр болон байнга оршин суугаа иргэдийн зорилгыг үндэслэн төрөлжсөн мэдээллийн сан бүрдүүлж, хөтлөх чиг үүргийг хэрэгжүүлэхэд 1, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гадаад улсын ажиллах хүчний талаар баримталж байгаа бодлого, шийдвэрийн Монгол Улсын ажиллах хүчний шилжилт, хөдөлгөөнд нөлөөлөх нөлөөллийн талаар судалгаа, дүн шинжилгээ

хийж Засгийн газарт тухай бүр танилцуулах үүргийг хэрэгжүүлэхэд 0.3 орон тоо тус тус шаардлагатай гэсэн тооцоолол гарсан байна.

Өөрөөр хэлбэл дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа байгууллага тухайн албан хаагчийн гүйцэтгэж буй үүрэг дээр нэмж гүйцэтгүүлэх замаар дотоод зохион байгуулалт хийн шийдвэрлэх боломжтой байна.

-----oOo-----

|                   | <b>Боомтын<br/>нэр</b> | <b>2008</b> | <b>2009</b> | <b>2010</b> | <b>2011</b> | <b>2012</b> | <b>2013</b> | <b>2014</b> | <b>2015</b> | <b>2016</b> | <b>2017</b> | <b>2018</b> |
|-------------------|------------------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|
| Гарсан зорчигчид  | Бүгд                   | 1,056,566   | 989,108     | 1,294,199   | 1,548,191   | 1,631,452   | 1,662,775   | 1,677,634   | 1,975,714   | 2,252,523   | 2,439,886   | 2,460,874   |
| Албан ажлаар      | Бүгд                   | 62,785      | 55,308      | 87,147      | 97,966      | 104,867     | 121,068     | 68,062      | 53,532      | 50,640      | 70,008      | 57,056      |
| Хувийн журмаар    | Бүгд                   | 922,578     | 863,919     | 1,103,977   | 1,331,607   | 1,390,959   | 1,397,950   | 1,412,489   | 1,642,834   | 1,769,853   | 1,792,427   | 1,776,664   |
| Жуулчлал          | Бүгд                   | 32,373      | 29,126      | 39,532      | 41,901      | 48,911      | 36,123      | 39,402      | 104,253     | 80,926      | 104,076     | 131,504     |
| Байнга оршин суух | Бүгд                   | 4,724       | 5,940       | 9,377       | 7,737       | 9,125       | 11,121      | 12,419      | 6,768       | 11,959      | 13,758      | 16,307      |
| Бусад             | Бүгд                   | 34,106      | 34,815      | 54,166      | 68,980      | 77,590      | 96,513      | 145,262     | 168,327     | 339,145     | 459,617     | 479,343     |
|                   |                        |             |             |             |             |             |             |             |             |             |             |             |
|                   |                        |             |             |             |             |             |             |             |             |             |             |             |
|                   |                        |             |             |             |             |             |             |             |             |             |             |             |
|                   |                        |             |             |             |             |             |             |             |             |             |             |             |
|                   |                        |             |             |             |             |             |             |             |             |             |             |             |
|                   |                        |             |             |             |             |             |             |             |             |             |             |             |